

## **ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ**

**НЭГ. Удирдлага, зохион байгуулалтын талаар:**

### **АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид хуралдаан гурван удаа зохион байгуулагдаж, 18 тогтоол гаргаж, 1 асуудалд тэмдэглэлээр үүрэг өглөө. Үүнд: School police ажиллуулах журам батлах тухай 2016 оны 61 дүгээр тогтоолын хэрэгжилт, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах орон тооны байнгын Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах журам батлах тухай, Бүсчилсэн хөгжлийн бодлогын саналд Өвөрхангай аймгаас оруулах Хөрөнгө оруулалт, бодлогын санал, Эрүүл мэндийн салбарын Хүний нөөцийн бодлого, Хүмүүнлэгийн хөтөлбөр батлах тухай, Гэр хорооллын стандарт батлах тухай, Иргэдийн дуу хоолой ба түүний үр нөлөө санал асуулгыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай, Эрдэнэ-Зуу музейн өмчлөлийн асуудлыг шийдвэрлэх, хадгалалт хамгаалалтыг сайжруулах тухай 2018 оны 25 дугаар тогтоолын хэрэгжилт, Боловсролын олон нийтийн зөвлөл байгуулах тухай 2015 оны 44 дүгээр тогтоолын хэрэгжилт, ЕБС, цэцэрлэгийн багш нарын амжилтыг үнэлэх журам батлах тухай 2016 оны 23 дугаар тогтоолын хэрэгжилт, Богд, Уянга, Хужирт сумдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж буй ажлын талаарх мэдээлэл зэргийг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Энэ оны 09 сарын 20-ний өдөр Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Удирдлагын академи, “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төсөлтэй хамтран зохион байгуулсан “Орон нутгийн түвшинд засаглалыг сайжруулж, хөгжлийг хангах нь” семинарт аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга болон Төлөвлөлт хяналтын тасгийн дарга нар оролцлоо.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг тэмдэглэх 24 дэхь өдрийг аймгийн салбар комиссоос сумдын ИТХ-д ажлын чиг үүрэг, зөвлөмж хүргүүлж, хэлмэгдэгсдийн төрөл төрөгсдөд хүндэтгэл үзүүлэх, хэлмэгдлийн хор уршгийн талаар иргэд болон хүүхэд багачуудад таниулах талаар чиглэл өгч, тус өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд аймгийн дүнгээр 140 гаруй иргэн, 1700 гаруй сурагчид оролцож, 1,7 сая гаруй төгрөгийг зарцууллаа. Хуулийн 13.2.1, 13.2.2 дахь заалтын дагуу улс төрийн хэлмэгдэгч Дүвжидийн Шийрэвийн нэр Зууны мэдээ сонинд нийтэд зарлагдаж, хэлмэгдэгч Жигжидийн Сэнгэдоржийн нөхөх олговрын нэхэмжлэлийг ЦАУЗУК-д хүргүүлэв.

### **АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Аймгийн удирдлагууд болон Засаг даргын Тамгын газрын хэлтэс, Засаг даргын дэргэдэх агентлаг, албадын дарга нарын ээлжит шуурхай хурлыг Мягмар гариг бүр зохион байгууллаа. Тус хурлаар аймгийн Засаг даргын зүгээс орон нутагт хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлуудыг шуурхайлах, ажлын гүйцэтгэл, чанарт тавих хяналтыг нэмэгдүүлэх, төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажилд сайтар анхаарахыг холбогдох байгууллагын удирдлагуудад үүрэг болгов.

Орон нутагт төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хөдөөгийн 88 багийн Засаг даргыг унаагаар хангаж, 6 багийн Засаг даргад зөөврийн компьютер хүлээлгэн өгөв.

Арвайхээр суманд 50 ортой хүүхдийн эмнэлэгийн барилга, усан бассейны барилгын угсралтын ажил үргэлжилж, 50 гаруй хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна.

Хужирт суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 36.2 м төмөр бетон гүүр, 0.7 км хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулж, нээлтийн үйл ажиллагаа зохион байгуулагдлаа.

“Монгол цэргийн нэгдсэн холбоо”-ны Өвөрхангай аймаг дахь салбар холбооны анхдугаар чуулган болж, тус төрийн бус байгууллагын Удирдах зөвлөлийн гишүүн, Монгол Улс, Оросын холбооны улсын баатар, сансрын нисгэгч Хошууч генерал Ж.Гүррагчаагаар ахлуулсан төлөөлөгчид, аймгийн Засаг дарга Г.Ганболд, Засаг даргын орлогч И.Доржсүрэн, Өвөрхангай аймгийн Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдлага, бие бүрэлдэхүүн нийт 350 гаруй хүн оролцлоо.

“Олон улсын ахмадын өдөр”-ийг тохиолдуулан аймгийн хэмжээнд мянган ахмадын чуулга уулзалтыг Тарагт сумын нутагт байрлах “Өгөөмөр” сувилалд зохион байгуулж, нийт 11.0 мянга гаруй ахмад настныг төлөөлж мянган ахмад орон нутгийн бодлого, үйл ажиллагаа түүний хэрэгжилтийн талаар хэлэлцэж, тэдний санал бодлыг сонссон бөгөөд уг арга хэмжээнд УИХ-ын гишүүд, аймгийн удирдлагууд оролцлоо.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн төвийн А хэсэгт дулаан үйлдвэрлэдэг томоохон 13 объектэд 20 ширхэг усан шүүлтүүрийг суурилуулах ажлыг гүйцэтгүүлж байна. Тус төхөөрөмж нь утааны өнгө, хөө, хүнд металлуудыг шүүж, агаарын бохирдлыг бууруулах юм.

Хужирт сумын төрийн байгууллагуудын болон багуудын “Нэгдсэн өдөрлөг” зохион байгуулж, УИХ-ын гишүүн Я.Содбаатар ард иргэдтэй уулзан, төрийн бодлого шийдвэр, Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, иргэдийн санал бодлыг сонссон юм.

### **ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮ**

Аймгийн улс болон орон нутгийн төсвийн 43 байгууллагын төсвийн хэрэгжилт, төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг ханган төлбөр тооцоог гүйцэтгэж, 9 дүгээр сард 1711 ш төлбөрийн хүсэлтээр 9,167,0 сая төгрөгийн гүйлгээг хийсэн байна.

Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр 11,366,3 сая төгрөгийн санхүүжилт авч сарчилсан хуваарийн дагуу орон нутгийн төсөвт байгууллагуудад хуваарилан санхүүжүүлсэн. Тусгай зориулалтын шилжүүлэгээр Ерөнхий боловсролын сургууль 20,714,2 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэг 8,173,5 сая төгрөг, Хүүхдийн хөдөлмөр хамгааллын үйлчилгээний тусгай шилжүүлэг 268,3 сая төгрөг, Эрүүл мэндийн тусгай шилжүүлэг 5,324,5 сая төгрөг, Газрын харилцаа, кадастрын тусгай зориулалтын шилжүүлэг 363,5 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 3,502,0 сая төгрөг санхүүжилт авч сарчилсан хуваарийн дагуу аймаг болон сумдын төсвийн байгууллагуудад хуваарилсан.

#### **Татвар төлөлт:**

Энэ оны 9 дүгээр сарын байдлаар 9 хуулийн этгээд нэмж бүртгүүлж, 1313 хуулийн этгээд, 129 салбар газар 604 төрийн бус болон төсөвт байгууллага, 28189 иргэний бүртгэлтэй нийт 302231 бүртгэлтэй татвар төлөгчийн бааз суурьтай үйл ажиллагаа явуулж байна. НӨАТатвар 292, онцгой албан татвар 2 татвар төлөгчийн тайланг хүлээн авсан.

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар хураах, техникийн хяналтын үзлэг 12,1 сая төгрөгийн агаарын бохирдлын төлбөрт 0.9 сая, Зам ашигласны төлбөрт 4,7 сая төгрөгийг орлогыг төвлөрүүлсэн.

Урд он болон тайлант оны өртэй 4 аж ахуйн нэгж байгууллагат мэдэгдэх хуудас гардуулан 8956,2 мянган төгрөгийн өрийг барагдуулсан.

Хяналт шалгалтаар шалгуулсан 4 аж ахуйн нэгж байгууллагын суутган тооцоолох хүсэлтийг шийдвэрлэсэн. 8-р сарын ebarimt-ийн тохиролд хонжвор хожсон 1 иргэний материалыг ТЕГ-т хүргүүлсэн. 36 иргэний газрын эрх шилжүүлэх гэрээний дагуу татвар ногдуулан ажилласан.

ТЕГ-ын даргын тушаалаар баталсан 2019 оны сүүлийн хагас жилийн "Татварын хяналт шалгалтанд хамруулах эрсдэл бүхий татвар төлөгчийн жагсаалт"-ын дагуу 2019 оны 09 сард татварын хяналт шалгалт хийх төлөвлөгөөтөөр 6, төлөвлөгөөт бусаар 3 ААН-ийг шалгах графикайг гарган хэлтсийн даргаар батлуулсан. 9 дугаар сарын хяналт шалгалтын мэдээг ТЕГ-т хүргүүлсэн. Сүүлийн хагас жилд хяналт шалгалтанд хамрагдах 28 ААН-д зөвлөмж хүргүүлсэн.

### **Нийгмийн даатгал**

Нийгмийн даатгалын сангуудын төлөвлөгөө 1694,8 сая төгрөг, гүйцэтгэлээр 1711,7 сая төгрөг төвлөрүүлж сангийн төлөвлөгөө 101 хувиар биелсэн байна.

9 сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт 2905 даатгуулагчдад тэтгэмжийн сангаас 2183,1 сая төгрөгний тэтгэмж олгов. Үүнд: ХЧТА 1104 даатгуулагчдад 111,9 сая төгрөг, ЖА-1188 даатгуулагчдад 1341,6 сая төгрөг, оршуулга 395 даатгуулагчдад 395.0 сая төгрөг, ажилгүйдлийн тэтгэмж 218 даатгуулагчдад 334,6 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Архив 352 лавлагаа гаргасан ба нийгмийн даатгалын шимтгэл төлсөн, төлөөгүй тодорхойлолт, цалингийн лавлагаа 283, ажилласан жил нөхөн тооцохын лавлагаа 46 гаргасан байна.

ЭХМК-ын 4 удаагийн хурлаар нийт 271 хүний хөдөлмөрийн чадвар алдалтын асуудлыг хэлэлцсэн ба үүнээс шинээр 33, цуцалсан 25, сунгасан 213 хүний хөдөлгөөний мэдээллийн баазад оруулсан.

Байцаагч, ажилчдыг үнэлэх үнэлгээний төхөрөмжөөр 9 сард 20 байцаагч 635 иргэд, даатгуулагчаас 85 үнэлгээ авсан байна. Уг үнэлгээгээр онц үнэлгээ өгсөн 75 даатгуулагч, сайн үнэлгээ өгсөн 10, дунд үнэлгээ өгсөн 0, муу үнэлгээ өгсөн 0 даатгуулагч байна. Үнэлгээ ирүүлээгүй даатгуулагч 86,6 хувийг эзэлж байна.

### **Санхүүгийн хяналт, аудитын алба**

Албаны даргын удирдамжаар Богд сумын ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, нийт 14211,2 мянган төгрөгийн зөрчилд, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 23 заалт бүхий зөвлөмж өглөө.

Албаны даргын удирдамжийн дагуу Хужирт сумын Эрүүл мэндийн төвийн 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд анхан шатны баримттай холбоотой 110,0 мянган төгрөг, цалин хөлстэй холбоотой 1973,3 мянган төгрөгийн зөрчил илэрч 8 заалт бүхий зөвлөмж хүргүүлэв.

Арвайхээр сумын 10 дугаар цэцэрлэгийн оны эхний хагас жилийн санхүүгийн баримтад дотоод аудит хийж, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан 500,0 мянган төгрөг, шийдвэргүйгээр олгосон үр дүнгийн урамшуулал 369,0 мянган төгрөг, анхан шатны баримтын бүрдэл дутуу 100,0 мянган төгрөгийн зөрчилд 6 заалт бүхий, Зүүнбаян-Улаан сумын цэцэрлэгийн 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, цалин хөлстэй холбоотой 1172,0 мянган төгрөг, анхан шатны баримтгүй 14,0 мянган төгрөгийн зөрчилд 5 заалт бүхий зөвлөмжийг тус тус хүргүүлээ.

Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас 2019 оны 8 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан “Эрүүл мэнд идэвхитэй хөдөлгөөн 5+” сургагч багш бэлтгэх сургалтад албаны бичиг хэргийн ажилтан хамрагдлаа.

### **ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд эрх зүйн сургалт, сурталчилгаа зохион байгуулах болон эрх зүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий “Эрх зүйн хөтөч” бэлтгэх сургалтыг зохион байгуулахаар бэлтгэх ажлыг ханган ажиллаж байна.

Нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар 3 албан тушаалтны холбогдох баримтуудыг бүрдүүлэн Авлигатай тэмцэх газарт хянуулж, дүгнэлт авлаа. Шинээр томилогдсон 3 албан тушаалтны хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогийн мэдүүлгийг цахим санд гаргуулан, баталгаажуулав.

### **АРХИВЫН ТАСАГ**

Аймгийн Архивын тасагт байгууллага, иргэдээс 1130 өргөдөл хүлээн авч 529 лавлагаа, 1961 хуулбар, 185 тодорхойлолт олгоод байна.

“Архивын тоо бүртгэл, эрэл хайлтын программ”-д 754 хадгаламжийн нэгжийн 65496 хуудас, 34813 заалт, 326728 хүний нэр, 52147 байгууллагын нэр, 59512 газар зүйн нэр бүхий захирамжлалын баримтыг цахим хэлбэрт шилжүүлсэн. Мөн 663хадгаламжийн нэгжийн 63382 хуудас баримтыг PDF холбож, 616 хадгаламжийн нэгжийн 45349 хуудас баримтыг Photoshop программд засварлаж оруулсан байна.

Түүнчлэн дөрвөн иргэний хүсэлтийг Дундговь, Хэнтий, Орхон аймгийн Архив, Нийгмийн даатгалын хэлтэст уламжилж шийдвэрлүүлэв. Аймгийн Шүүх, Прокурорын газар, Цагдаагийн газар, Шүүхийн шинжилгээний алба зэрэг байгууллагуудад үзлэг явуулсан. Мэдээлэл технологи Үндэсний паркаас зохион байгуулсан сургалтанд 5 ажилтан хамрагдсан. Хадгамжийн сан дахь 1 хөмрөгийн баримтад иж бүрэн нягтлан шалгалт хийсэн.

### **ЦАГДААГИЙН ГАЗАР**

Цагдаагийн газарт 2019 оны эхний 9 сард 3365 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь 836 буюу +33.1 хувиар өссөн, үүнээс гэмт хэргийн шинжтэй 693, зөрчлийн шинжтэй 2672 гомдол мэдээлэл бүртгэгдсэн байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 636 буюу 91.7 хувийг 5 хоногт, 48 буюу 6.9 хувийг 6-аас дээш хоногт, зөрчлийн шинжтэй гомдлын 2261 буюу 84.6 хувийг 3 хоногт, 397 буюу 14.8 хувийг 4-өөс дээш хоногт шийдвэрлэсэн байна.

Гомдол мэдээллийн 23 нь буюу 0.6 хувийг шийдвэрлээгүй буюу хуулийн хугацаанд шалгаж байна.

Аймгийн хэмжээнд оны эхний 09 сард 353 холбогдогчтой, 1311.7 сая төгрөгийн хохиролтой, 495 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулан шалгасныг урьд оны мөн үетэй харьцуулахад 54 хэргээр буюу +12.2 хувиар өссөн, хэргийн илрүүлэлт 37.6 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс -3.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хэргийн төрлөөр: - Хүний амьд явахын эсрэг гэмт хэрэг гэмт хэрэг 16 бүртгэгдэж, 7 буюу +77.7 хувиар, - Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 27 бүртгэгдэж 17-оор буюу +2.7 дахин, - Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 262 бүртгэгдэж 60-аар буюу +29.7%, - Залилах гэмт хэрэг 20 бүртгэгдэж 5-

аар +33.3 хувиар, - Мал хулгайлах гэмт хэрэг 43 бүртгэгдэж 19 буюу +79.1 хувиар, - Дээрэмдэх гэмт хэрэг 9 бүртгэгдэж, 7-оор буюу +4.5 дахин, - Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 24 бүртгэгдэж 11-ээр буюу +84.6 хувиар тус тус өсч,

Хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг 131 бүртгэгдэж 31-ээр буюу -- 19.1 хувиар буурсан, - Авто тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 24 бүртгэгдэж 14-өөр буюу -36.8 %-иар буурч, - Тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг 15 бүртгэгдэж 26-аар буюу -2.7 дахин тус тус буурсан байна.

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргүүд нь бүртгэгдсэн гэмт хэргийн дотор 84.8 хувийн эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 09 дугаар сарын байдлаар өмчлөх эрхийн эсрэг 262 гэмт хэрэг бүртгэгдснээс иргэдийн өмчийг хулгайлах 147, малын хулгайлах гэмт хэрэг 43, тээврийн хэрэгсэл хулгайлах 15, дээрэмдэх 9, залилах 20 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулан шалгасныг урьд оны мөн үетэй харьцуулахад 60 буюу +29.7 хувиар, Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 24 бүртгэгдэж 11-ээр буюу +84.6 хувиар тус тус өссөн байна.

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 131 бүртгэгдэж 31-өөр буюу -19.1 хувиар буурсан, Авто тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 24 бүртгэгдэж 14-оор буюу -36.8 %-иар тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Иргэдийн өмчийн хулгайн гэмт хэргийн дийлэнх хувийг цонх хагалах, хөших, цонхоор орох, гэр, орон сууцны хаалга, цоожийг нь эвдэж орох, малын хулгайн гэмт хэрэг нь иргэдийн хараа хяналт сонор, сэрэмж сул, малаа байнга хариулага маллагаагүй орхидог, цахимаар иргэдийг хууран мэхэлж, итгэл эвдэх байдлыг ашиглан үйлдэгдэж байна.

Нийт бүртгэгдсэн 495 гэмт хэргээс 156 буюу 31.5 хувийг согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг эзэлж байна.

Зөрчил өмнөх оноос 14855 буюу +87.7 хувиар өссөн байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажын үр дүн, олон нийтийн эргүүл, байнгын пост, цагийн менежменттэй постуудыг ажиллуулснаар тодорхой үр дүнд хүрч байгаагаар тодорхойлогдож байна.

Нийт бүртгэгдсэн 31788 зөрчлөөс согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 1575 зөрчил байгаа нь өмнөх оны мөн үеэс 277-оор буюу +21.3 хувиар өссөн байна.

## **ДӨРӨВ. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАР**

### **БОЛОВСРОЛ, СОЁЛ**

Боловсрол, соёл, урлагийн газрын даргын даргын 2019 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн удирдамжийн хүрээнд Лаборатори Мэргэд сургууль, Арвайхээр сумын ерөнхий боловсролын 4, 5 дугаар сургууль, Арвайхээр сумын 1,2,6,3 дугаар цэцэрлэгүүдэд зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллалаа. Тус ажлын хүрээнд 187 багшаас мэргэжлийн шалгалт, хууль эрх зүйн шалгалт, хичээл заадаг ангиас нь стандарт хэрэгжилтийн шалгалт авч үнэлгээ дүгнэлт өглөө. Мөн 122 багшийн хичээлд сууж арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар Боловсролын тухай хуулийн 23.1, БСШУ-ны сайдын 2013 оны 353 дугаар тушаалын хүрээнд холбогдох материалаа ирүүлсэн Арвайхээр сумын ЕБ-ын 5-р сургууль, Арвайхээр сумын ЕБ-ын Тэмүүлэл-Эрдэм сургууль, Арвайхээр сумын 13 дугаар цэцэрлэг, Арвайхээр сумын хувийн хэвшлийн "Арвайхээр-Нархан", "Дэлгэрэх хөгжлийн гэрэл", "Бидэнд хайрлагдах

зүрх", Уянга сумын "Нархан мөрөөдлийн хотхон" зэрэг 4 цэцэрлэг, нийт 2 сургууль, 5 цэцэрлэгт аймгийн Засаг даргын 2019 оны А/596, А/597 дугаар захирамжаар сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олголоо.

Улаанбаатар хотод зохион байгуулагдсан ЯХИС-аас хэрэгжүүлж байгаа "Монгол улсад хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах" төслийн сургалтад 1 мэргэжилтэн хамрагдсан.

Аймгийн хэмжээнд хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж буй байгууллагуудын тогооч нарын "Ур чадвар-2019" уралдаан 2019.09.27-нд Арвайхээр суманд зохион байгууллаа.

Өвөрхангай аймгийн тогооч нарын ур чадварын түвшинг Монгол улсын жишигт ойртуулах, нутгийн брэнд хоолыг шинээр бий болгох, олон арван мастер тогооч бэлтгэх зорилготойгоор 5 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдаж байна.

"Ур чадвар-2019" уралдаанд нийт 9 сумын 70 орчим тогооч хүрэлцэн ирж 7 төрлөөр өрсөлдөж байгаа нь өмнөх жилүүдийн уралдаанаас илүү өргөн цар хүрээг хамран уралдааны чансаа сайжирч байна. Тус уралдаанд Сургуулийн өмнөх боловсролын байгууллагаас 29 тогооч ЕБ-сургуулиас 3 тогооч оролцлоо.

Аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгуулж байгаа "Ирээдүйн инженерүүд-4" олимпиадыг БСУГ, ХГБЗХГ, Хужирт сумын ЕБС хамтран Хужирт суманд 2019-09-20-оос 21-ны өдрүүдэд зохион байгууллаа. Олимпиадад 15 сургуулийн 1-12-р ангийн 200 гаруй сурагч, 50 гаруй багш оролцож, 5 төрлөөр аваргуудаа шалгаруулж тус бүр өргөмжлөл, медаль, мөнгөн шагнал хүртэж, багийн дүнгээр Арвайхээр сумын 1-р сургууль, Мэргэд, Хархорин-2 сургууль эхний 3 байрт шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа.

Арвайхээр сумын сургуулиуд хамран сургах тойргийн дагуу сурагчдаа элсүүлж байгаа талаар хяналт тавьж, хамтран ажиллав.

Аймгийн Засаг даргын "Бүтээлч Өвөрхангай-2020" үйл ажиллагааны хөтөлбөрт тусган хэрэгжүүлж байгаа орон нутагт соёл, урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, соёл, урлагийн үйлчилгээнд хамрагдах иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Өвөрхангай аймгийн БСУГ-ын СУХ, Аймгийн ХДТ, Аймгийн Музей, Төв номын сангийн хамт олон Бүрд суманд Соёлын өдөр зохион байгууллаа.

Монголын соёлын ажилтны урлагийн анхдугаар их наадам зохион явагдлаа. Уралдаанд Монгол улсын 330 сумын соёлын байгууллагын уран бүтээлчид өрсөлдөв. Улсын хэмжээнд шилдэг 21-т шалгараад байсан Гучин-Ус сумын соёлын төвийнхөн эцсийн шалгаруулалтын дүнгээр улсад гуравдугаар байр эзэлсэн өндөр амжилт үзүүллээ.

Уянга сумын Жаргалант багийн уугуул Гончигдоржийн Намхайдагвын мэндэлсний 100 жилийн ойг аймгийн Засаг даргын дэргэдэх БСУГ, Аймгийн музей, түүний үр хүүхдүүд хамтран тэмдэглэн өнгөрүүллээ. Г.Намхайдагва-100" эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгууллаа. Г.Намхайдагва түүх археологийн өргөн мэдлэгтэй, өөрийн байгууллагыг бэхжүүлж, музейн үзмэрийн баяжилтыг нэмэгдүүлэхэд монголын олон арван судлаач археологичидтой хамтран ажиллаа.

МУ-ын Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолын дагуу Соёл, урлагийн ажилтны өдрийг аймгийн соёл, урлагийн байгууллагууд Гучин-Ус суманд тэмдэглэн өнгөрүүллээ.

Найрагч Цэвэгмэдийн Гайтавын мэндэлсний 90 жилийн ой энэ онд тохиож байна. Их зохиолчийн уугуул нутаг Богд сумын ЗДТГ-аас түүний мэндэлсний 90 жилийн ойг тохиолдуулан олон арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж байна. Тухайлбал, МЗЭХ, МҮОНРТ-тэй хамтран зохиолчийн амьдрал, уран бүтээлийн замналаар дурдатгалын ном бүтээх, хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулах,

Богд сумын ЕБС-ийн сурагчдын уран бүтээлийг сурталчлах зэргээр ажиллаж байна. Их зохиолчийн уран бүтээл, алдар гавьяаг мөнхжүүлэх, хойч үед сурталчлан түгээн дэлгэрүүлэх, хүүхэд багачууд, ардын авьяастнуудын авьяас билгийг нээн хөгжүүлэх зорилгоор “Уран уншлагын аймгийн уралдаан”-ыг “Үндэсний бичиг үсгийн өдөр”-өөр зохион байгууллаа. Уралдаанд 40 орчим уран уншигч оролцож, түүний уран бүтээлийг дээжлэн үзэгч олноо хүргэв.

## **ЭРҮҮЛ МЭНД**

“Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, хөгжил, нийгмийн баталгааг хангах хөгжүүлэх хөтөлбөр 2019-2022” –г аймгийн Засаг даргын зөвлөл болон аймгийн Иргэдийн хурлын тэргүүлэгчдын хурлаар оруулж батлууллаа.

“Шинэ төгсөгч нарыг ажлыг чиглүүлэх” сургалтыг 2018-2019 онд шинээр ажилд орсон 40 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд зохион байгууллаа.

“Залуу нас-Гэрэлт ирээдүй” төслийн хүрээнд зорилтот бүлгийн 200 хүнээс мэдлэг, хандлага, дадлын судалгааг авч, дүгнэлт хийсэн. Мөн ЕБС-ийн сурагчдын дунд “Би өөрийгөө бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлж чадна” Дэвжээ тэмцээнийг төслийн багийнхантай хамтран зохион байгуулж, 3 сургуулийн 6 баг оролцсон, шторкны уралдаан зарлаж дүгнэсэн.

“Эрүүл мэндийн анхан шатны нэгжид үзүүлж буй сүрьеэгийн тусламж үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд Уянга, Нарийнтээл сумдад бичил уурхай эрхлэгч 436 гаруй ажилчдыг сүрьеэгийн үзлэгт хамруулж, сүрьеэгээс урьдчилан сэргийлэх сургалтад хамруулж, мэдлэг олгосон. Нийт 15161 хүн амбулаторийн үзлэгт хамрагдаж, ТТӨ-542, алсын дуудлага-868, ТТӨ-48, АЗХХ-43 тохиолдол бүртгэгдсэн байна.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран “Тамхинаас гаргах зөвлөгөө өгөх” сургагч багш бэлтгэх сургалтыг БОЭТ, сум, өрхийн ЭМТ-ийн 35 эмч, мэргэжилтнийг хамруулан зохион байгуулав.

## **ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖИЛ**

Тус газраас Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил хамгааллын чиглэлээр хэрэгжиж буй үйл ажиллагаатай танилцаж, эрчимжүүлэхээр Арвайхээр суманд ажиллаж байна. Салбарын хүрээнд хэрэгжиж буй хууль тогтоомж, хүүхэд, гэр бүл, залуучуудын асуудлаар хэрэгжүүлж бодлого, үйл ажиллагаатай танилцаж, Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг хэлэлцэж, мэргэжил арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэхээр Арвайхээр сумын 13 баг, ЕБ-ын 4 сургууль, 13 цэцэрлэгүүд дээр ажиллаж байна. Мөн Багуудын хамтарсан багийн гишүүдтэй хамтран гэр бүлийн туршилтын хөтөлбөрт хамрагдаж буй 227 өрхүүдийн нөхцөл байдалд хяналт хийж, эрсдлийн програмд бүртгэгдсэн эрсдэлт нөхцөлд амьдарч буй 223 хүүхдүүдийн мэдээллийг нягталж, нөхцөл байдлыг судлан ажиллаж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, түүний харьяа байгууллагуудын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, иргэдэд хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээг үзүүлэхээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/289 дүгээр тушаал, Төрийн нарийн бичгийн даргын “Нээлттэй өдөрлөг зохион байгуулах тухай” 3/2767 дугаар албан бичгийг дагуу аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын газар, Өвөрхангай аймаг дахь Политехник коллеж хамтран төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээрх цогц үйлчилгээг нэг цэгээс хүргэх зорилгоор

“ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ”-ийг Аюуш баатарын талбайд зохион байгууллаа.

Монгол Улсын Их Хурлын гишүүн, гавьяат хуульч Д.Лүндээжанцангийн нэрэмжит Хангайн болон говийн бүсийн аймгуудын өсвөрийн шатарчдын “Багийн аварга” шалгаруулах тэмцээн зохион байгуулагдсан. Тус тэмцээнд Өмнөговь, Булган, Өвөрхангай аймгийн бүсээс шалгарсан эрэгтэй, эмэгтэй 7 насны ангиллаар 11 багийн 160 гаруй тамирчид оролцсон.. Уг арга хэмжээг аймгийн ЗДТГазар, Гэр бүл, хүүхэд хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Өвөрхангай аймаг дахь Шатрын холбоо, магадлан итгэмжлэгдсэн Өвөрхангай аймаг дахь политехнологийн коллеж хамтран зохион байгууллаа.

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар, Онцгой байдлын газар, БСУГазар, МУЗН-ийн Өвөрхангай аймаг дахь салбар хамтран “Өсвөрийн аврагч-2019” аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг өнөөдөр зохион байгуулсан. Тэмцээнд 6 сумын 12 багийн 80 гаруй баг тамирчид оролцож, өсвөрийн аврагчид жагсаалын үзлэг, мэдлэг сорих асуулт, хариулт, усанд осолдогчийг аврах, анхны тусламж үзүүлэх, ур чадвараа сорих, химийн хордолт зэрэг зургаан цэгт гамшгаас хамгаалах мэдлэг, ур чадвараа сорин, аваргуудаа шалгаруулахаар өрсөлдсөн байна.

Энэ оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар сургалтын их танхимд 47 удаагийн сургалт зохион байгуулагдаж нийт 5345 иргэн хамрагдаж, дээрх үйл ажиллагаануудад техник хэрэгсэл, байр танхимаар үйлчилж ажиллалаа.

Хүүхдийн ордны дэргэдэх дугуйлан, сургалтуудын хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагаа 2019 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр 10:00-16:00 цагийн хооронд Хүүхдийн ордны гадна талбайд амжилттай болж өнгөрлөө. Нээлтийн үеэр урлагийн тоглолт, дугуйлангуудын танилцуулга, хүүхдүүдийн бүтээлийн үзэсгэлэн, дугуйлангуудын нэмэлт элсэлтийг зохион байгууллаа. Нийт 64 хүүхдийг шинээр бүртгэж, дугуйлан сургалтуудтай холбоотой мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллаа.

2014 оноос эхлэн жил бүр “Залуучуудын хөгжлийн сарын аян”-ыг өрнүүлдэг уламжлал тогтсон. Энэхүү аяны хүрээнд залуучуудын хөгжил, тэдэнд тулгамдаж буй асуудлын шийдэл, боломжийг эрэлхийлэх, залуучуудын бодит оролцоог дэмжих олон арга хэмжээ зохион байгуулдаг. Өвөрхангай аймгийн ГБХЗХГазрын Залуучуудын хөгжлийн төв тус аяныг “Залуусын хүч” уриатай зохион байгуулж байна. Тус арга хэмжээнд 40 гаруй гэр бүл гэр бүлийн гишүүдтэйгээ, 100 гаруй хүүхэд багачууд буюу нийт 200 гаруй өсвөр үе, хүүхэд залуучууд хүрэлцэн ирлээ.

Залуучуудын хөгжлийн төвөөс түүх соёлын өвийг хамгаалах, эх оронч үзлийг төлөвшүүлэх, ардын урлаг, ёс заншил, уламжлалт зан үйлийг хөгжүүлэх, зөв амьдрах ухааныг таниулан үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, өсвөр үе, залуучуудын оролцоог хангах зорилгоор Ерөнхий боловсролын болон Политехникийн коллежийн ахлах болон дунд ангийн сурагчдын дунд “Үндэсний өв уламжлалаа өвлүүлж, хөгжүүлэе” арга хэмжээг 2019 оны 09 дүгээр сарын 17-ний өдөр “Хүүхдийн ордон”-д амжилттай зохион байгууллаа. Тус арга хэмжээнд нийт 6 багийн 24 сурагч оролцож авьяас чадвараараа өрсөлдлөө. Тухайн арга хэмжээний хүрээнд өсвөр үе, залуучуудыг үндэсний ёс уламжлал түүх соёлоо дээдлэн хүндэтгэх, ардын урлаг, ёс заншил, уламжлалт зан үйлийг хөгжүүлэх зорилгоор олон төрлийн тэмцээн уралдаан зохион байгуусан.

Цахим мэдээллийн сувгуудаар дамжуулан танин мэдэхүйн мэдээллийг өсвөр үе, залуучуудад түгээх, эерэг нөлөөллийг бий болгох зорилгоор сошиал төлөвлөгөө батлуулж хэрэгжилтийн ханган ажиллаж байна. Фэйсбүүк цахим сувгаар 2019 оны 07 дугаар сарын 1-ээс 9 дугаар сарын 1 –ний өдөр хугацаанд төлөвлөгөөний дагуу цахим орчинд мэдээ, мэдээлэлдээ нийтэлж олон нийтэд түгээн ажилласан.



“ЗАЛУУСЫН ХҮЧ” залуучуудын хөгжлийн сарын аяны хүрээнд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Залуучуудын хөгжлийн төвөөс спортлог, эх оронч үзэлтэй залуусыг дэмжих, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, спортоор дамжуулж хүмүүжил төлөвшилд нөлөөлөх зорилгоор 15-34 насны өсвөр үе, залуучуудын дунд “3х3” сагсан бөмбөгийн тэмцээнийг төвийн сагсны талбайд амжилттай зохион байгууллаа. Тус тэмцээнд 6 багийн 24 тамирчид оролцлоо. Нэг баг үндсэн 3 тоглогч, сэлгээний 1 тоглогч нийт 4 гишүүний бүрэлдэхүүнтэй оролцсон.

ГБХЗХГ-ын Залуучуудын хөгжлийн төвөөс Аймгийн ЗДТГазрын дэргэдэх Боловсрол соёл, урлагын газар, Аймгийн Насан туршийн боловсролын төв, Өвөрхангай аймгийн эрүүл мэндийн газартай хамтран “Залуу нас-Гэрэлт ирээдүй” аяныг зохион байгуулж байгаа билээ. Тус аяны хүрээнд Өсвөр үе, залуучуудыг бэлгийн замаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх, хамгаалах, тусламж үйлчилгээний талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, мэдээллийг олон талт эх үүсвэрээр дамжуулан түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Би өөрийгөө бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс сэргийлж чадна” уриатай жүжигчилсэн тоглолтын тэмцээнийг Ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн сурагчид болон Политехникийн коллежийн оюутнуудын дунд зохион байгууллаа. Тус тэмцээнд нийт 6 багийн 48 залуучууд хамрагдаж идэвх санаачлагатай оролцлоо.

“Залуусын хүч” сарын аяны хүрээнд амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, төрийн болон төрийн бус байгууллага, салбар дундын хамтын ажиллагаа, идэвх оролцоог нэмэгдүүлэх замаар ард иргэдийн идэвхтэй хөдөлгөөний талаарх ойлголтыг нэмэгдүүлж, цаашид ажлын байрны дасгал хөдөлгөөнийг тогтмолжуулж, эрүүл зан үйлийг бий болгож олон нийтийн хандлагыг өөрчлөх зорилгоор “Эрүүл мэнд-Идэвхтэй хөдөлгөөн 5+” уралдааныг албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн дунд зарласан.

“Залуусын хүч” аяны хүрээнд “Өвөрхангай аймгийнхаа хүүхэд, залуусын авьяас чадварыг хөгжүүлэх, дуу хөгжмөөр дамжуулан гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэх, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор 15-34 насны залуучуудын дунд “Залуусын дуу хоолой” дуу, флаш моб бүжгийн уралдааныг 2019 оны 8 дугаар сарын 28-ний өдрөөс 2019 оны 9 дүгээр сарын 13-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгууллаа. Уралдаанд 3 төрлийн флаш моб /10 гишүүнтэй/, 35 төрлийн гоцлол дуу буюу нийт 50 гаруй өсвөр үе, залуучууд оролцсон.

“Залуусын хүч” сарын аяны хүрээнд зохион байгуулж буй “12 ажил – 12 санаачлага” нөлөөллийн үйл ажиллагааг сурталчлах, амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх сургалтад өсвөр үе, залуучуудыг хамруулах зорилгоор Ерөнхий боловсролын сургуулийн ахлан болон дунд ангийн сурагчид, Политехникийн Коллежын оюутнуудыг хамруулан сургууль тус бүр дээр нь очиж Амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх сургалт болон мэргэжил сонголтын талаар зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээ, хувь хүний хөгжил болон манлайлал зэрэг сэдвийн хүрээнд сургалт зохион байгууллаа. Нийт 509 өсвөр үе, залуучуудын хамрууллаа.

“Залуусын хүч” сарын аяны хүрээнд Өвөрхангай аймгийн спорт аялалын холбоотой хамтран өсвөр үе, залуучуудын иргэний үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж байгаль орчноо хайрлан хамгаалах сэтгэлтэй болгох, өөрийн өсч буй орчинтойгоо танилцаж түүхэн замналыг нь таниулах мөн цэвэр агаарт алхангаа хүрээлэн буй орчныхоо хог хаягдлыг цэвэрлэх зорилгоор 2019 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр “ГҮЙЕ, ТҮҮЕ” үүргэвчтэй явган аялалыг зохион байгууллаа. Тус аялалд 18 залуучууд хамрагдсан

## **БИЕИЙН ТАМИР, СПОРТ**

Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан Монгол улсын Засгийн газрын 2011 оны 32 дугаар цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн ахмад настануудын мэдлэг туршлагыг залуу хойч үедээ түгээн дэлгэрүүлэх, хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн биеийн тамир, спортын арга хэмжээг зохион явууллаа. Тус арга хэмжээг спортын 4 төрлөөр 2 насны ангиллаар зохион байгуулан давхардсан тоогоор 494 ахмад өрсөлдлөө. Тэмцээнд Хархорин, Арвайхээр, Тарагт сумдын ахмадын хороо эхний байруудыг эзэллээ.

Монголын хүүхдийн спортын VI их наадам 2019 оны 09 дүгээр сарын 07-15-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдлаа. Тус наадамд 21 аймаг, 9 дүүргийн 4588 тамирчид оролцож үндсэн төрөлд спортын 19, сонгох 5, паралимп 4, дифлимп 2, тусгай 3 төрлөөр тус тус өрсөлдлөө.

Наадамд манай аймгаас спортын 16 төрлөөр 165 тамирчин, 22 дасгалжуулагч оролцож хүндийн өргөлт 5 алт, 4 мөнгө, 1 хүрэл, чөлөөт бөх 1 алт, 1 хүрэл, даам 1 алт, таеквондо 2 мөнгө, 2 хүрэл, жүдо бөх 1 мөнгө, бокс 1 мөнгө, хөнгөн атлетик 2 хүрэл, самбо бөх 1 хүрэл, спорт бүжиг 2 мөнгө, тусгай олимп 1 алт, 1 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 7-р байр эзэллээ.

Их наадмын хамгийн зохион байгуулалт сайтай 6 аймгийн нэгээр шалгарч цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан. Тус наадамд ЕБ-ын 249 сургуулийн тамирчид оролцсоноос арвайхээр сумын 2-р сургууль 5 дугаар байр, 1-р сургууль 21 дүгээр байруудыг эзэлж наадмын өргөмжлөл, цомоор шагнагдлаа.

Пауэрлифтингийн Азийн аварга шалгаруулах тэмцээн 09 дүгээр сарын 06-12 нд Монгол улсад зохион байгуулагдаж 9 орны 305 тамирчин оролцлоо. Тус тэмцээнд Д.Мөнхсүлд дасгалжуулагчтай 2 тамирчин хэрэглэл мөнгө, хүрэл, мастер 2 ангиллын 66кг-ын жинд С.Богд-Очир алтан медаль тус тус хүртлээ.

## **НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ХЭЛТЭС**

Энэ оны 9 дугаар сарын 25-ны байдлаар аймгийн хэмжээнд байнгын 604, түр 163, улирлын 112 шинэ ажлын байр тус тус бий болсон байна. Нийт шинэ ажлын байрыг эдийн засгийн салбарын ангиллаар авч үзвэл хөдөө аж ахуйн салбар 13 хувь, боловсруулах үйлдвэрлэлд 26 хувь, бөөний худалдаа 14 хувь, боловсролын салбарт 11 хувь, уул уурхайд 1 хувь, барилгын салбарт 12 хувь бусад салбарт 23 хувийг тус тус ж эзэлж байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний ганцаарчилсан зөвлөгөө мэдээлэлд 531 иргэнийг хамруулж, ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллагаас 629 ажлын байрны захиалга хүлээн авч 578 иргэнийг ажлын байранд зуучиллаа.

Уянга, Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий, Хархорин, Баян-Өндөр, Бүрд, Есөнзүйл сумдад залуу малчин өрхийг малжуулах арга хэмжээг зохион байгуулж, 52 малчин өрхөд зочилж, малчдын аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгсөн.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд малжуулах арга хэмжээнд хамрагдах хүсэлтэй 110 малчны төслийг хүлээн авч, төслийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, залуу малчин өрхийг малжуулах арга хэмжээг зохион байгуулах 2 ажлын хэсэг хангайн болон говийн сумдад ажиллаж, одоогийн байдлаар нийт 65 өрхийг малжуулаад байна. Малжуулах арга хэмжээг 9 дүгээр сард багтаан бүрэн зохион байгуулж, малчдын туршлага солилцох, уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

2019 оны 09 сард улс болон орон нутгийн төсвөөс нийт 11408.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг авч нийгмийн халамжийн тэтгэвэрт 1521 иргэнд 1947.2 тэрбум төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмжид 2362 иргэнд 1288.1 сая төгрөг, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 2146 иргэнд 791.2 сая төгрөг, ахмад

настаны нийгмийн халамжийн үйлчилгээнд 7490 иргэнд 688.0 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэмжид 475 иргэнд 159.7 сая төгрөг, жирэмсэн хөхүүл эхийн тэтгэмжид 2108 иргэнд 318.7 сая төгрөг, хоол тэжээлийн тусламж дэмжлэгт 13137 иргэнд 937.3 сая төгрөг, алдар цолтон ахмад настануудын тэтгэмжид 38 иргэнд 49.1 сая төгрөг, алдарт эхийн тэтгэмжид 10187 иргэнд 1350.7 тэрбум төгрөг, насны хишгийн зардалд 5523 иргэнд 867.1 сая төгрөг, цалинтай ээж хөтөлбөрт 6899 иргэнд 2250.1 сая төгрөг, өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжид 288 иргэнд 175.0 сая төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 145 иргэнд 3.8 сая төгрөг, амьжиргаа дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшууллын зардалд 11.3 сая төгрөг, банкны шимтгэлд 5.3 сая төгрөг нийт давхардсан тоогоор 52319 иргэнд 10914.1 тэрбум төгрөгийн тэтгэвэр тэтгэмжийг олгосон байна.

Аймгийн хэмжээнд дахин судалгаанд хамрагдах 43, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдахийг хүссэн 4, нийт 47 өргөдөл хүлээн авч шийдвэрлэн, шинээр төрсөн 279 хүүхдийг бүртгэж ажиллалаа.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд зохион байгуулагддаг өдрийн үйлчилгээнд 80 ахмад настан, амьдрах ухааны сургалтад Арвайхээр сумаас хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа 338 иргэн хамрагдсан болно. Тухайлбал: Өдрийн үйлчилгээнд Арвайхээр сумаас 20, Хайрхандулаан сумаас 30, Уянга сумаас 30 ахмад настан тус тус хамрагдсан байна. Мөн тус үйлчилгээнд Арвайхээр сумаас хөгжлийн бэрхшээлтэй 20 иргэн хамрагдсан байна. Түр байрлуулах, асрамжлах үйлчилгээнд 2 иргэн 5 хүүхэд хамрагдсан байна.

Цахим эрхийн бичгийн үйлчилгээг олгох ажлыг зохион байгуулж 905 өрхийн 4705 иргэнд 57008,0 мянган төгрөгийн эрхийн бичгийг олгосон байна.

“Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-т Арвайхээр сумаас хамрагдаж буй өрхийн 91 гишүүнд “Нийгмийн халамж”-ийн чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, “Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцын тухай болон идэвхжүүлэх сургалт, арга хэмжээг зохион байгуулж витаминжууллаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс 2 удаагийн хуралдаан зохион байгуулж 13 хүүхдийн асуудлыг хэлэлцсэн байна. Үүнээс 8 хүүхдийн байнгын асаргааг шинээр тогтоож, 2 хүүхдийн байнгын асаргааг сунгаж, 1 хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй болохыг тодорхойлж, 1 хүүхдийн байнгын асаргааг цуцалж, мөн 1 хүүхдийг онош тодруулах шаардлагатай гэсэн шалтгаанаар буцаасан байна. Хурлаар хэлэлцсэн 13 хүүхдээс 1 хүүхдэд боловсрол эзэмшүүлэх дүгнэлт гаргасан бол 6 хүүхэд боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаа болно.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд зохион байгуулж буй өдрийн үйлчилгээнд хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй 15 иргэнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль” болон холбогдох бусад хууль тогтоомжийн чиглэлээр мэдээлэл зөвлөгөө өгч ажиллалаа.

## **ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ДЭД БҮТЦИЙН САЛБАР**

### **ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН**

Газар эзэмших эрх шилжүүлэх хүсэлт 3, газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах хүсэлт 2-г хүлээн авч шийдвэрлэсэн.

Арвайхээр сумын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөд туссан 175 айлын хаус хороололд газар эзэмших эрх шинээр авсан 4 иргэнд нэгж талбар болон

байшингийн хил зааг, эргэлтийн цэгийг газарт буулгах хэмжилтийг хийж тэмдэгжүүлсэн.

Аймгийн Засаг даргын захирамж болон Орон нутгийн өмчийн газрын “Гэрээ байгуулах эрх олгох тухай” албан тоотын дагуу Баян-Өндөр сумын Багийн төвийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч “Гуа орд” ХХК-тай гэрээ байгуулав.

Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий, Хужирт, Хархорин сумдад хийгдэж буй барилга угсралт, их засварын ажлуудад хяналт хийж, Хархорин сумын 5 дугаар цэцэрлэг, 2 дугаар сургууль, 4 дүгээр цэцэрлэгт хийгдсэн засварын ажлыг хүлээн авав.

Аймгийн ЗДТГазрын барилгын засварын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулав.

БХТөвийн захиалагчийн хяналтын инженерийн хамт Баянгол, Төгрөг, Гучин-Ус, Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Хайрхандулаан, Уянга, Тарагт сумдад хийгдэж буй барилга угсралт, их засварын ажилд хяналт хийв.

### **БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

БОАЖЯамнаас улс орон даяар зохион байгуулж буй “Хоггүй цэвэрхэн монгол” аяны хүрээд тус газраас “Бүх нийтээрээ амьдрах орчноо хамтдаа цэвэрлэцгээе” уриаг зарлаж сар бголгон зарлаж сумдад албан тоотоор чиглэл өгч ажиллаа. “Хоггүй цэвэрхэн монгол” аяны хүрээнд аймгийн 19 сумын дунд “ Хоггүй цэвэрхэн сум” болзолт уралдааныг зарлаж удирдамжийг хүргүүллээ. Түүнчлэн “Хоггүй цэвэрхэн Монгол” аяны урилга бүхий 3х5 хэмжээтэй самбарыг Арвайхээр сумын нийтийн эзэмшлийн самбарт байршуулав.

Ерөнхий боловсролын 9-11 дүгээр ангийн сурагчдаар Дайргийн голын 60,000 кв талбайг цэвэрлэж хогийн цэгт нийлүүлэх ажлыг зохион байгууллаа.

Аймгийн аялал жуулчлалын дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулж хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болсон.

Аймгийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах саналыг нэгтгэж ЗДТГ-ын ХОХБТХэлтэст албан тоотоор хүргүүллээ. Тус газрын даргын баталсан удирдамжын дагуу ажлын хэсэг Тарагт сумын нутагт амралт, сувилалын үйл ажиллагаа явуулж буй “Өгөөмөр”, “Хүрэмт”, “Олимп”, “Од”, “Олон дов” зэрэг газруудын үйл ажиллагаатай танилцаж, илэрсэн зөрчил дутагдлуудыг арилгуулах талаар холбогдох сумдад албан бичиг хүргүүллээ.

БОАЖЯам, Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас зохион байгуулсан Орон нутагт аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх боломж, тулгамдаж буй асуудал сэдэвт улсын зөвлөгөөн 2019 оны 09 дүгээр сарын 12-13-ны өдрүүдэд Баянхонгор аймагт зохион байгуулагдаж тус газрын дарга мэргэжилтнүүд оролцлоо.

### **МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР**

Мал эмнэлгийн ерөнхий газрын ажил эрчимжүүлэх 01/911 дугаар тоотын дагуу мал угаалга, малын эрүүл мэндийн үзлэгийн мэдээ, бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын явцын мэдээг сумдын МЭТасгаас авч нэгтгэн өдөр бүр 16:00 цагт МЭГГазарт мэдээлж ажиллаж байна.

Мал эмнэлгийн газрын Малын туулга, угаалгын ажлыг эрчимжүүлэх № 96 зөвлөмжийг мал эмнэлгийн тасгуудад хүргүүлсэн.

ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А-274 дүгээр тушаалын дагуу манай аймагт хувиарлагдсан мал угаалгын зөөврийн төхөөрөмж 4 ширхэгийг хүлээн авч Баян-Өндөр, Баянгол, Зүүнбаян-Улаан, Хархорин сумдад хувиарлаад байна.

Арвайхээр суманд үйл ажиллагаа явуулж байгаа “ӨВ-ЭКО МИЙТ”, “ДЭЛХИЙН ХҮНС” махны үйлдвэрт явцийн хяналт шалгалтыг хийж мэргэжил арга зүйн

зөвлөгөө өгч, махнаас дээж авч, аймгийн МЭАЦТЛ-т шинжилээ хийж, ариутгал, халдваргүйтгэлийн хийсэн.

“ӨВ ТҮНШЛЭЛ-2019” арга хэмжээнд оролцож байгаа мал болон малын гаралтай бүтээгдэхүүнд хяналт шалгалтыг хийж, шинжилгээнд хамрагдаагүй бүтээгдэхүүнээс дээж авч шинжилүүлж, ирсэн бүх малаас цусны дээж авч шинжлүүлж хариуг тухайн малчинд хүргүүлсэн. Үүнд МЭЛаборатори ажиллаж Бүрд, Гучин-Ус, Сант, Төгрөг, Өлзийт, Хархорин, Богд зэрэг сумдаас ирүүлсэн сүү,сүүн бүтээгдэхүүний/аарц аарцан бүтээгдэхүүн/ 20 дээжинд шинжилгээг түргэн шуурхай хийж хариуг эздэд нь цаг тухайд үйлчилсэн. Мөн Ийлдэс судлалыг лаб-д Бог малын мялзан шүлхий өвчний тандалт шинжилгээнд 4 сумын 8 багийн 200 хонь, 200 ямаа нийт 400 дээжинд ID vet PPR Competition AB ELISA, цуврал LOT-FO5 оношлуурыг ашиглан шинжилгээ хийхэд шинжилгээгээр 400 бүгд сөрөг/-/ дүн үзүүлсэн.

Ариун цэврийн лабораторид: Сүү, сүүн бүтээгдэхүүний 22, Мах махан бүтээгдэхүүний 2 дээжинд шинжилгээ хийж хариуг түргэн шуурхай эздэд нь олгож ажилласан Аймагт иргэн, аж ахуй нэгж, компаний үйлдвэрлэл, худалдааны зориулалтаар худалдан авч маллаж байгаа малын судалгаа гаргаж заасан цаг хугацаанд нь МЭГазарт хүргүүлсэн.

Эрдэнэ хайрханы өгөөж, Эх-Онги, Их Чандмань өндөр, Хурдан хээр, Шинэ онги, Зос хангай, Тарагт жирэм, Тэрмийн буян, Баянцариг, Угалзхангай, Довийн хөндий, Баян сүргийн буян, Хүнхэр хүүш, Жаргалантын зон зэрэг МЭҮНэгжүүдэд 1436 ш эрүүл мэндийн гэрчилгээ олгосон.

Арвайхээр суманд үйл ажиллагаа явуулж байгаа түүхий эдийн болон мал нядалгааны нийт 5 цэгийн 1466 мкв талбайд халдваргүйтгэл хийсэн.

Ийлдэс судлалыг лаб-д бог малын мялзан шүлхий өвчний тандалт шинжилгээнд 4 сумын 8 багийн 200 хонь, 200 ямаа нийт 400 дээжинд ID vet PPR Competition AB ELISA, цуврал LOT-FO5 оношлуурыг ашиглан шинжилгээ хийхэд шинжилгээгээр 400 бүгд сөрөг/-/ дүн үзүүлсэн.

### **УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ**

Энэ сард агаарын дундаж температур 9.4–14.8 градус дулаан, нийт нутгаар шөнөдөө 0-8 градус дулаан, өдөртөө 15-22 градус дулаан байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундажтай харьцуулж үзвэл нийт сумдын нутгаар 1.5-3.3 градус дулаан байсан байна.

Салхи: Нийт нутгаар салхи секундэд 3-8 м/сек, Богд, Баруунбаян-Улаан, Төгрөг сумдын нутгаар 14-17 м/сек хүрч салхилсан байна.

Хур тунадас: Энэ сард Богд, Нарийнтээл, Өлзийт сумдын нутгаар тунадас ороогүй, бусад сумдын нутгаар 0,5 мм -9,5 мм тунадас орсон байна.

Хөдөө аж ахуйн цаг уур: Бэлчээрийн даацыг тооцоолж гаргасан дүнгээс үзвэл нийт нутгийн: 0% нь 50 хүртэлх хувь (бэлчээрийн нөөцтэй), 7,4% нь 51-100 хувь (бэлчээр хүрэлцээтэй), 31,5% нь 101-300 хувь (даац 1-3 дахин хэтэрсэн), 23,2% нь 301-500 хувь (даац 3-5 дахин хэтэрсэн), 37,8% нь 500 хувиас их (даац олон дахин хэтэрсэн) байна. Өөрөөр хэлбэл нийт нутгийн 10 орчим хувьд нь өвөл-хаврын бэлчээрийн даац хүрэлцээтэй байхаар харин 90 гаруй хувьд хэтэрч гарлаа.

Энэ зун Хархорин, Уянга, Богд сумдын нутгаар зуншлага хэвийн, бусад нутгаар 7 дугаар сарын сүүлчээс зуншлагын байдал дээрдэж байна. Зуншлага хэвийн байсан зарим нутагт нэг наст болон хөл газрын ургамал түрж ургасан, ургамал тачир сийрэг байгаагаас нэгжийн ургац муу, зуншлага оройтсон газраар ургамлын бүтээмж гүйцээгүй байгаа нь даац хэтэрч гарах шалтгаан болсон.

Бэлчээрийн даац хүрэлцээтэй Хархорин, Батөлзий, 3-5 дахин хэтэрч гарсан сумдад Өлзийт, Есөнзүйл, Баян-Өндөр, Богд, Хужирт сумд орж байгаа бол Уянга,

Нарийнтээл, Баруунбаян-Улаан, Хайрхандулаан, Гучин-Ус, Тарагт, Зүүнбаян-Улаан, Сант, Баянгол, Бүрд сумдад даац олон дахин хэтэрч гарсан.

Цаг агаарын хоногийн урьдчилсан мэдээг аймгийн сум бүрээр нарийвчилан зохиож аймгийн төр захиргааны удирдлагуудад факсаар, сумдын цаг уурын салбараар дамжуулан малчидад хүргэхийн зэрэгцээ, [www.tsag\\_agaar.mn](http://www.tsag_agaar.mn) цахим хуудсанд өдөр бүр тавьж нийтийн хэрэгцээнд үйлчилсэн. Энэ сард гаргаж үйлчилсэн цаг агаарын нарийвчилсан мэдээний таарц нь 94.1 хувь, хоногийн урьдчилсан мэдээний таарц нь 91.9 хувь, цаг агаарын аюул агаар мэдээний ирц болон чанар 100 хувь байлаа.

### **СУМДЫН МЭДЭЭЛЭЛ**

Нарийнтээл суманд 3 дугаар улирлын байдлаар хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санд 11080 эрх зүйн акт бүртгэж, эрх сургалтыг 15 удаа, хэлэлцүүлэгт хамрагдсан 136 иргэн, хуулийн гарын авлага 1088 ширхэгийг тарааж ажилласнаас гадна Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Гэр бүлийн хүчирхийлэлийн тухай хуулиудыг багийн иргэдийн нийтийн хурлаар хэсэгчилсэн байдлаар хийсэн ба нийт 154 иргэнд гарын авлага материал тарааж ажилласан.

Хайрхандулаан суманд иргэний бүртгэлийн албаны мэдээгээр өссөн дүнгээр шинээр төрсөн 6, эцэг тогтоолгосон 4, нас барсан 1, иргэний үнэмлэх дахин авсан 6, иргэний үнэмлэхний сунгалтаа хийлгүүлсэн 8, Гэрлэлтийн гэрчилгээ дахин авалт 1, лавлагаа 3, төрөлт бүртгэлийн лавлагаа 5, төрсний гэрчилгээ дахин авалт 5-ийг бүртгэсэн байна. Өөр аймагруу 1, баг хооронд 2 иргэн 2 хүүхэд шилжиж явсан, сумаас сумруу 11 иргэн 9 хүүхэд шилжин явж, сумаас суманд 5 иргэн 2 хүүхэд шилжин ирсэний бүртгэлийг хийгдсэн.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР